



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн сан,
2023 оны 03 сарын 02
өдөр хүлээн авсан.

2023 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

“Радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д
өөрчлөлт оруулах тухай

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 88 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 1.2, 1.4 дэх хэсэгт дараах өөрчлөлтийг оруулсугай.
1.1.Нөхцөл, шаардлагын 1.2 дах хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” гэснийг “Зөвшөөрлийн тухай хууль” гэж, 1.4 дэх хэсгийг “Төлбөртэй радиоогийн үйлчилгээнээс бусад радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоход Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5-д заасны дагуу сонгон шалгаруулна.” гэж тус тус өөрчлөн найруулах.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Т.НАРАНМАНДАХ